



МОНГОЛ САВХИ

ХУВЬЦААТ КОМПАНИ

20¹⁴ оны 08 сарын 05 өдөр

Дугаар 031

Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД

Тайлан хүргүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасны дагуу компанийн 2014 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүргүүлж байна.

Жич: Тайланг хавсаргав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Х. Хуушаан* Д.ХУУШААН



“Монгол савхи” ХК-ийн 2014 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Нэр: “Монгол савхи” ХК

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, “Монгол савхи” ХК-ийн байр 607 тоот
Утас: 345757

Улсын бүртгэлийн мэдээлэл: Улсын бүртгэлийн №: 9010001065, регистр №: 2075148

“Монгол савхи” ХК нь анх 1941 онд ЗХУ-ын мэргэжилтэний тусламжаар арваад оёдлын машинтай “Суран тоноглол”-ын тасаг нэртэйгээр байгуулагдан цэрэг, дарга суран бүс үйлдвэрлэж байсан. Уг тасаг нь өргөжин “Тоноглолын фабрик” нэртэй болсон.

Улмаар 1960 онд Чехословак Улсын хөрөнгө оруулалтын тусламжтайгаар Чехословак Улсын тоног төхөөрөмжөөр тоноглогдон савхин хувцас үйлдвэрлэх үйлдвэр болон хөгжиж ирсэн. Уг үйлдвэр нь 1988 онд Югослав Улсын тусламжтайгаар барууны үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжөөр тоноглогдон сардаа 100 орчим сая төгрөгийн савхи, савхин эдлэл үйлдвэрлэдэг, 1000 гаруй ажилтан, ажиллагсадтай орчин үеийн үйлдвэр болон хөгжиж ирсэн.

1994 онд савхин эдлэлийн “Уян” ХК нь торгон савхины “Угалз” ХК-д нэгдэн одоогийн “Монгол савхи” ХК болж, савхи боловсруулан, савхин эдлэл үйлдвэрлэдэг байсан.

“Монгол савхи” ХК нь 1998 онд хувьчлагдсан. Хувьчлагдах үедээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Төрийн өмчийн хороо, татварын байгууллага, нийгмийн даатгалын байгууллага, Болгарын элчин сайдын яам зэрэг газруудад мөн компаниудын хооронд үүссэн их хэмжээний өртэй байсан. Компанийн хуучин удирдлагууд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг зарсан байсан тул тоног төхөөрөмж, мэргэжлийн ажилчид байхгүй, их хэмжээний өртэй зэрэг шалтгааны улмаас савхин эдлэлийн үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон юм. Үүнээс хойш түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн ба их хэмжээний өрийг шат дараалалтайгаар төлж барагдуулсан.

Тус компанийн хамт олны дундаас Хөдөлмөрийн баатар 7, Төрийн шагналт 2, Аж үйлдвэрийн гавъяат ажилтан 1 зэрэг алдар цуутан төрөн гарсан түүхтэй.

Одоо тус компани нийт 13 ажилтан, ажиллагсадтай, өөрийн үл хөдлөх эд хөрөнгийг бусад аж ахуйн нэгж байгууллагуудад оффис, үйлдвэрлэлийн зориулалтаар түрээслэх үйл ажиллагаа эрхлэн явуулж, түрээсийн орлогоор үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэн өр үүсгэхгүй ажиллаж байна.

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, татвар, нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

2014 оны эхний хагас жилд 147,540,300 төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнээс цалин хөлсний зардалд 50,904,000 төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 5,323,000 төгрөг, засвар үйлчилгээний зардалд 22,510,700 төгрөг, ашиглалтын зардалд 38,463,800 төгрөг, удирдлагын зардалд 4,493,800 төгрөг, газрын төлбөрт 1,479,300 төгрөг, ҮХЭХАТ-7,640,000 төгрөг, ХХОАТ-4,359,400 төгрөг, ААНОАТ-870,200 төгрөг, НӨАТ-16,774,600 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийт 15000 м² талбай бүхий объектийн 1,2,6 давхаруудыг түрээслүүлж байна. 3,4,5 давхарын нийт 7500 м² талбай хоосон байна. Цаашид хоосон давхаруудыг урт хугацаагаар, давхараар нь түрээслүүлэх, хуучин сантехникийн шугам хаалт, паарыг засварлах, солих, барилгын дотоод, гадаад чанарыг сайжруулахын тулд засвар,

арчилгаа хийх, байрны гадна тохижилтыг сайжруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Компани тус үйлдвэрт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан Хөдөлмөрийн баатар 7, Төрийн шагналт 2, Аж үйлдвэрийн гавъяат ажилтан 1 хүмүүст улирал бүр буцалтгүй тусламж үзүүлж, мөн жил бүр 500 орчим өндөр настаныг цагаан сарын үеэр хүлээн авч урамшуулал олгодог.

Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд орсон өөрчлөлт байхгүй. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд байхгүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Д.Ганболд, Д.Хуушаан, Д.Мөнхсайхан, Г.Ганчимэг, Ч.Тогтохбаяр, А.Цэцэгдэлгэр, хараат бус гишүүдээр Т.Жамбал, Г.Баттулга, С.Ундармаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Д.Ганболд, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ц.Сувдаа, гүйцэтгэх захирлаар Д.Хуушаан нар ажиллаж байна.

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Д.Хуушаан	Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	11 жил
2	Д.Ганболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	14 жил
3	Д.Мөнхсайхан	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	10 жил
4	Г.Ганчимэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	7 жил
5	Ч.Тогтохбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн, ня-бо	дээд	10 жил
6	А.Цэцэгдэлгэр	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	10 жил
7	Т.Жамбал	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	2 жил
8	Г.Баттулга	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
9	С.Ундармаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
10	Ц.Сувдаа	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд	1 жил

Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хуушаан 236,281 ширхэг хувьцаа, ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Тогтохбаяр 90,961 ширхэг хувьцаа, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Мөнхсайхан 456,417 ширхэг хувьцаа тус тус эзэмшдэг.

ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хуушаан, Д.Ганболд, Д.Мөнхсайхан, А.Цэцэгдэлгэр нар “Жуулчин говь” ХК, “Мандалговь-Импекс” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр, ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Тогтохбаяр “Жуулчин говь” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Мөнхсайхан “Хар хорин интернейшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц.Сувдаа “Жуулчин говь” ХК, “Мандалговь-Импекс” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар тус тус ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар нь хоорондоо гэр бүл, ураг төрлийн холбоогүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нарын 80 хувь нь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан. Сургалтанд хамрагдаагүй 2 гишүүнийг 8 сард сургалтанд хамруулахаар төлөвлөж байна.

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Г.Баярмаа	хувиараа	14%
2	Д.Мөнхсайхан	“Хар хорин интернейшнл” ХХК-ийн Гүйцэтгэх захирал	18,4%
3	Ч.Цэцэг-Өлзий		21%
4	Д.Хуушаан	“Монгол савхи” ХК-ийн Гүйцэтгэх захирал	9,5%

2014 оны 2-р улирлын санхүүгийн тайлангийн хураангуй:

/мян.төг/

№	а.Үлдэгдлийн тэнцэл	01 сарын 01	06 сарын 30
1	Мөнгөн хөрөнгө	1 374,1	1 890,5
2	Авлага	238 608,5	238 652,5
3	Мал амьтан	1 885,2	1 885,2
	Эргэлтийн хөрөнгийн дүн	247 297,5	242 469,7
4	Үндсэн хөрөнгө	1 356 254,9	1 356 254,9
5	Биет бус ба хөрөнгө оруулалт	70 376,4	70 376,4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1 426 631,4	1 426 631,4
	Нийт хөрөнгийн дүн	1 673 928,9	1 669 101,1
6	Богино хугацаат өглөг	53 367,4	53 367,4
7	Урт хугацаат өглөг	-	-
	Өр төлбөрийн дүн	58 419,6	55 475,1
8	Эзний өмч	247 534,3	247 534,3
9	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1 486 241,1	1 486 241,1
10	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	- 108 266,1	- 111 200,4
	Эзэмшигчийн өмчийн дүн	1 615 509,3	1 613 626,0
	Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	1 673 928,9	1 669 101,1
	б. Орлого үр дүнгийн тайлан		
13	Цэвэр борлуулалт		147 569,1
14	ББӨ		-
15	Нийт ашиг		147 569,1
16	Үйл ажиллагааны зардал		150 416,8
17	Үйл ажиллагааны ашиг		-2 847,7
18	Үйл ажиллагааны бус орлого		
19	Үйл ажиллагааны бус зардал		
20	Ердийн ажиллагааны ашиг, алдагдал		
21	Орлогын татварын зардал		86,5
22	Тайлант үеийн ашиг алдагдал		-2 934,2

2014 оны хагас жилийн байдлаар 147 540 300.00 төгрөгийн орлоготой 150 416 878.76 төгрөгийн зарлагатай, 2 934 291.74 төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө оны эхэнд 1 374 100 төгрөг, бэлэн мөнгө 162 226 500 төгрөг, зарцуулалт 162 761 100 төгрөг, бэлэн мөнгөний үлдэгдэл 1 890 600 төгрөг байна. Зардлыг бүтцээр нь авч үзвэл 97.53 хувийг үйл ажиллагааны зардал, 2.47 хувийг бусад зардал эзэлж байна. 2013 оны жилийн эцсээр 8 029 372.09 төгрөгийн ашигтай ажилласан бол 2014 оны хагас жилийн байдлаар 2 934 291.74 төгрөгийн алдагдалтай гарсан нь зардал нэмэгдсэнтэй холбоотой юм.

Компанийн үндсэн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй. Компани их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгээгүй, урт богино хугацааны зээл аваагүй болно.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд 10:00 цагт зарлан хуралдуулж, хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын олонхын саналын эрхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан, Аудитын хорооны тайланг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.
2. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр Д.Ганболд, Д.Хуушаан, Д.Мөнхсайхан, Г.Ганчимэг, Ч.Тогтохбаяр, А.Цэцэгдэлгэр нарыг, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Т.Жамбал, Г.Баттулга, С.Ундармаа нарыг тус тус сонгов.
3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 73 хувийн саналаар ТУЗ-ийн 2014 оны зардлын төсвийг 41 820 000 төгрөгөөр баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороодыг байгуулан ажиллуулж байна.